

31 ИЗРАИЛИЙН ҮНДЭСНИЙ НИЙГМИЙН ХУУЛЬ

НӨХЦӨЛТ, ТАНЫ СОНГОЛТ

31.1 Ерөөл эсвэл шүүлт

²⁷Хэрэв та нар өнөөдөр миний тушааж буй ЭЗЭН Бурханыхаа тушаалыг сонсвол ерөөгдөх болно. ²⁸Хэрэв та нар ЭЗЭН Бурханыхаа тушаалыг сонсолгүй, харин миний өнөөдөр та нарт тушааж буй ёс журмаас хазайж, урьд мэддэггүй байсан өөр бурхдыг дагаваас хараагдах болно. ²⁹ЭЗЭН Бурхан чинь чиний эзэмшихээр очиж буй тэр газарт чамайг аваачин оруулах үед чи Геризим уулан дээр ерөөлийг, Ебал уулан дээр хараалыг тавь! (Дэд хууль 11:27-29АБ 2004)

¹³ЭЗЭН цааш нь надад “Би энэ ард түмнийг харлаа. Үнэхээр тэд бол хөшүүн хүзүүтэй ард түмэн байна. ¹⁴Надад бүү саад хий. Би тэднийг устгаж, тэдний нэрийг тэнгэрийн доороос арчин хаяж, чамайг тэднээс илүү хүчтэй, илүү агуу үндэстэн болгоно” гэсэн. (Дэд хууль 9:13-14 АБ 2004)

¹¹Бурхад нь бурхад биш байхад үндэстэн нь бурхдаа сольсон уу? Харин Миний хүмүүс яруу алдраа ашиг тусгүй зүйлээр сольжээ. (Иеримиа 2:11 АБ 2004)

¹³Учир нь Миний хүмүүс хоёр бузар мууг үйлдсэн билээ: Тэд өөрсдөдөө зориулан ус тогтоож чаддаггүй эвдэрхий нөөцлүүрүүдийг чулуу ухан хийхийн тулд амийн усны ундарга болох Намайг умартсан юм. ¹⁷Түүний чамайг замаар удирдан явахад чи ЭЗЭН Бурханаа орхисноор үүнийг өөртөө үйлдээгүй гэж үү? (Иеримиа 2:13 АБ 2004)

¹⁷Түүний чамайг замаар удирдан явахад чи ЭЗЭН Бурханаа орхисноор үүнийг өөртөө үйлдээгүй гэж үү? (Иеримиа 2:17 АБ 2004)

²⁵Та нарын гэм буруу эдгээрийг эргүүлсэн бөгөөд та нарын нүгэл өөрсдөөс чинь сайныг нуув. (Иеримиа 5:25 АБ 2004)

⁸Та нар мөн энэ хүмүүст “ЭЗЭН ингэж айлдаж байна. “Үзэгтүн, Би та нарын өмнө амь болон үхлийн замыг тогтоодог. (Иеримиа 21:8 АБ 2004)

¹⁹Хэрэв та нар зөвшөөрч, дуулгавартай дагавал, энэ газрын хамгийн сайныг иднэ. ²⁰Харин та нар эсэргүүцэж босвол, илдээр цавчигдана” гэж ЭЗЭНий ам айлдаж байна. (Исаиа 1:19-20 АБ 2004)

[] Ямар хүмүүс ерөөлөөс илүү хараалыг сонгодог бөгөөд яагаад гэдгийг та мэдэх үү?

[] Та хараалыг биш ерөөлийг хэрхэн сонгохоо мэдэх үү?

[] Бурхан дэлхийг захирдаг гэдэгт та итгэдэг үү?

[] Одоо үйлдсэн бүх нүгэл нь шүүлт дээр шүүгдэх болно гэдгийг та мэдэх үү?

[] Таны бүх үйлдэл тэрхүү шүүлтээр орох болно гэдгийг та мэдэх үү?

31.2 Бурхан Израилийг ЭЗЭНтэй уулзуулахаар ариусган бүргэдийн далавч мэт авардаг

¹Израилийн хөвгүүд Египет газраас гарснаас хойш гурав дахь сарын яг тэр өдөр Синаин цөлд хүрэв. ²Тэд Рефидимээс хөдөлж, Синаин цөлд хүрч, цөлд буудаллав. Израильчууд тэндээ нэгэн уулын өвөрт буудаллав.

³Мосе Бурхан уруу өгсөн очсонд, ЭЗЭН түүнийг уулаас дуудан -Чи Иаковын гэрт, Израилийн хөвгүүдэд ингэж хэл. ⁴“Би египетчүүдэд хэрхэн хандаж, та нарыг бүргэдийн жигүүр дээр тээн, яаж Өөртөө авчирсныг та нар өөрсдөө харсан.

⁵Одоо хэрэв та нар Миний дуу хоолойг дуулгавартай дагаж, Миний гэрээг сахивал та нар бүх ард түмнүүдийн дундах Миний эзэмшил болно. Учир нь бүх дэлхий Минийх. ⁶Та нар Надад тахилч нарын хаанчлал, ариун үндэстэн болно”. Эдгээр үгсийг чи Израилийн хөвгүүдэд хэл гэв. ⁷Тийнхүү Мосе ирж, ард түмний ахмадуудыг дуудан, өөрт нь ЭЗЭНий тушаасан эдгээр бүх үгсийг тэдэнд хэлэв.

⁸Бүх ард түмэн нийтээрээ -ЭЗЭНий айлдсан бүхнийг бид биелүүлнэ гэгцгээв. Мосе ард түмний үгийг ЭЗЭНд дамжуулав. ⁹ЭЗЭН Мосед -Үзэгтүн, Миний чамтай ярихыг ард түмэнд сонсож, тэднийг чамд үүрд итгүүлэхийн тулд Би чам уруу өтгөн үүлээр очно гэв. Мосе ард түмний үгийг ЭЗЭНд хэлэв.

¹⁰Бас ЭЗЭН Мосед -Ард түмэн уруу очиж, тэднийг өнөөдөр, маргааш ариусган хувцсыг нь угаалга. ¹¹Тэднийг гурав дахь өдөрт бэлтгэ. Учир нь гурав дахь өдөрт ЭЗЭН бүх ард түмний нүдний өмнө Синаи уулан дээр бууж ирнэ. ¹²Чи ард түмний төлөө уулын эргэн тойронд хүрээ татаад, “Уулан дээр гарах буюу хормойд нь хүрэхээс болгоомжил. Ууланд хүрсэн аливаа хүнийг заавал алах ёстой. ¹³Тэр хүнд гар хүрч болохгүй. Харин түүнийг чулуугаар шидэж, эсвэл сумаар харвах ёстой. Хүн ч бай, мал ч бай амьд үлдэх ёсгүй” гэж хэл. Хуцын эврэн бүрээ удаан хүнгэнэхэд тэд уул өөд гарч ир гэв.

¹⁴Тийнхүү Мосе уулаас буун ирж, ард түмнийг ариусгав. Тэд өөрсдийн хувцсыг угаав. ¹⁵Мосе ард түмэнд-Гурав дахь өдөрт бэлтгэцгээ. Эмэгтэй хүнд бүү ойрт гэв.

¹⁶Гурав дахь өдрийн өглөө уулыг өтгөн үүл бүрхэн, тэнгэр дуугарч, аянга цахилгаан цахилж, асар хүчтэй бүрээн дуу хүнгэнэсэнд хуаранд байсан бүх ард түмэн дагжин чичрэв.

¹⁷Бурхантай уулзахаар Мосе ард түмнийг хуарангаас дагуулан гарч, тэд уулын бэлд зогслоо. ¹⁸Бурхан галаар буун ирсэн учир Синаи уул бүхэлдээ утаанд автав. Утаа нь зуухны утаа шиг хөөрч, уул бүхэлдээ асар хүчтэй доргиж байлаа. ¹⁹Дараа нь бүрээн дуу улам улмаар чангарахад Мосе ярьж, Бурхан аянга мэт дуугаар түүнд хариулав. ²⁰ЭЗЭН Синаи уулан дээр, уулын орой дээр залран буусан. ЭЗЭН Мосег уулын орой уруу дуудсанд Мосе очив. ²¹ЭЗЭН Мосед -Бууж очоод, ард түмэнд хатуу анхааруул. Тэд ЭЗЭНийг үзэх гэж дайрч, олноороо үхэх вий.

²²ЭЗЭНд ойртон ирэх тахилч нар бас өөрсдийгөө ариусгаг. Эс тэгвэл ЭЗЭН тэдний эсрэг дайрна гэв. ²³Мосе ЭЗЭНд -Ард түмэн Синаи ууланд гарч чадахгүй. Учир нь Та “Уулыг тойруулан хүрээ татаж, уулыг ариусга” гэж анхааруулсан билээ гэв. ²⁴Тэгэхэд ЭЗЭН түүнд -Бууж очоод, Ааронтай хамт

гарч ир. Харин тахилч нар ба ард түмэн ЭЗЭНд ойртохоор бүү дайраг. Эс тэгвэл Тэр тэдэн уруу дайрна гэв. ²⁵Тиймээс Мосе ард түмэн уруу бууж, тэдэнд хэлэв. (Египетээс гарсан нь 19:1-25 АБ 2004)

[] Израильчуудыг цөлийн туршид аварсан нь Мосе биш харин Бурхан гэдгийг та мэдэх үү?

[] Бурхан Өөрийн хүмүүстэй хэзээ, хэрхэн хамт оршдогийг та мэдэх үү?

[] Та эргэн тойрныхоо хүмүүсийн хувьд өөрийгөө хэн бэ гэдгээ мэдэх үү?

[] Бурханы өгсөн эрх мэдэл, үүрэг хариуцлага, нэр төр өөрчлөгдөхгүй гэдгийг та мэдэх үү?

[] Та дэлхийн ямар нэгэн ч саналаар бус Бурханаар сонгогдсон гэдгээ мэдэх үү ?

[] Шүтлэг гэж юу болохыг та мэдэх үү?

[] Тахилчаар ариусгагдахаас нааш сонгогдсон хүмүүс ч хүртэл яагаад Бурхан уруу ойртож очиж болохгүйг та мэдэх үү ?

31.3 Овгийн төлөө Мосегийн эцсийн ерөөл

Мосе овгуудыг ерөөв.

¹Бурханы хүн Мосе үхэхийнхээ өмнө Израилийн хөвгүүдийг ерөөсөн ерөөл нь нэ болой. ²Тэр хэлэхдээ -ЭЗЭН Синайгаас ирж, тэдний төлөө Сеир уулаас босож, Паран уулаас гэрэлтэж, түмэн ариун хүмүүсийн дундаас ирсэн. Түүний баруун мутарт нь галт хууль байсан. ³Үнэхээр Тэр ард түмнүүдийг хайрладаг, бүх ариун хүмүүс нь Таны мутарт байна. Тэд Таны хөлд хэвтэн Таны үгийг хүлээн авна. ⁴Мосе бидэнд хууль зарлиг буулгасан. Тэр хууль нь Иаковын чуулганы өмч юм. ⁵Ард түмний тэргүүн нар цугларч, Израилийн овгууд хамт байх үед Тэрээр Иешурунд хаан байжээ. (Дэд хууль 33:1-5 АБ 2004)

[] Христэд итгэсэн үедээ та ямар төрлийн ерөөл хүлээн авсанаа мэдэх үү?

31.3.1 Реубен

⁶Реубен үхэлгүй амьдарч, түүний хүмүүс цөөрөхгүй байх болтугай гэв. ⁷Иудагийн тухайд тэр ингэж хэлэв. -Өө, ЭЗЭН, Иудагийн дуу хоолойг сонсооч. Түүнийг өөрийнх нь ард түмэнд аваачаач. Тэр өөрийнхөө төлөө гараараа тулалдсан. Дайснаа дарахад нь Та туслах болтугай. (Дэд хууль 33:6-7 АБ 2004)

31.3.2 Леви

⁸Левийн тухай тэр хэлэв. -Таны Туммим, Таны Урим нь Таны бурханлаг хүнд байх болтугай. Та түүнийг Массад туршиж, Мерибагийн усны дэргэд түүнтэй маргалдсан билээ. ⁹Тэр эцэг эхийнхээ тухай “Би тэднийг харж үзээгүй” гэж хэлсэн. Тэр ах дүүсээ хүлээн зөвшөөрөөгүй, өөрийн хөвгүүдээ ч танихгүй байсан. Учир нь тэд Таны үгийг даган мөрдөж, гэрээг тань сахисан болой. ¹⁰Тэд Таны хууль тогтоолыг Иаковд, Таны хуулийг Израильд зааж, Таны өмнө утлага уугиулан, тахилын ширээн дээр тань шатаалт тахилыг бүхлээр нь өргөнө. ¹¹Өө, ЭЗЭН! Түүний эд хөрөнгийг ивээж, түүний гарын үйлсийг хүлээн аваач. Түүнийг эсэргүүцэгчдийн, үзэн ядагчдын ууцыг нь хугалж, дахин босож чадахгүй болгооч! (Дэд хууль 33:8-11 АБ 2004)

31.3.3 Бениамин

¹²Бениамины тухай тэр хэлэв. -ЭЗЭНд хайрлагдагч нь Түүний дэргэд амар тайван суух болтугай. Тэр түүнийг өдөржин хамгаалж, түүнийг далныхаа хооронд суулгана. (Дэд хууль 33:12 АБ 2004)

31.3.4 Иосеф

¹³Иосефын тухай тэр хэлэв. -Түүний нутгийг ЭЗЭН ерөөж, тэнгэрийн үнэт зүйлс, шүүдэр ба газрын гүнд хадгалагдах усаар, ¹⁴нарны ургуулдаг үнэт жимсээр, сарны гаргадаг үнэт бүтээлээр, ¹⁵эртний уулсын хамгийн сайн зүйлсээр, мөнхийн

толгодын үнэт зүйлсээр, ¹⁶газрын үнэт зүйлс хийгээд түүнийг дүүргэдэг бүхнээр, бутан дотор оршиж байсан Түүний ивээлээр ивээх болтугай. Тэр ерөөл нь Иосефын толгой дээр, ах дүүсийнхээ дунд ялгарсан нэгний толгойн титэм дээр буух болтугай. ¹⁷Түүний сүр хүч нь ууган тугал шиг, түүний эвэр нь зэрлэг үхрийн эвэр шиг бөгөөд түүгээрээ ард түмнүүдийг газар дэлхийн хязгаар хүртэл түрнэ. Тэд бол Ефраимын түмтүүд, Манассегийн мянгатууд болой. (Дэд хууль 33:13-17 АБ 2004)

31.3.5 Зебулун/Иссахар/Гад

¹⁸Зебулуны тухай тэр хэлэв. -Зебулун аа! Чи гарахдаа баярлагтун.

Иссахар аа! чи асар дотроо баярлагтун. ¹⁹Тэд ард түмнүүдийг уулын зүг дуудаж, тэндээ зөв шударгын тахилыг өргөнө. Тэд далайн арвин зүйлс, элсэнд нуусан эрдэнэсийг сорж авна.

²⁰Гадын тухай тэр хэлэв. -Гадыг агуу том болгогч нь ерөөлтэй еэ! Гад эм арслан шиг хэвтэж гар болон толгойн оройг урна. ²¹Тэр өөртөө дээжийг нь харсан. Тэнд захирагчийн хувь хадгалагдсан байсан. Тэр ард түмний удирдагчидтай хамт ирж, ЭЗЭНий шударга ёс ба Израильтай тогтоосон хууль тогтоолыг нь гүйцэтгэсэн билээ. (Дэд хууль 33:18-21 АБ 2004)

31.3.6 Дан/Нафтали

²²Даны тухай тэр хэлэв. -Дан бол Башанаас үсрэн гарч буй арслангийн зулзага болой. ²³Нафталийн тухай тэр хэлэв. -Ивээлд цадаж, ЭЗЭНий ерөөлөөр дүүрсэн Нафтали аа! Чи өрнөд хийгээд өмнөдийг эзэмш. (Дэд хууль 33:22-23 АБ 2004)

31.3.7 Ашер

²⁴Ашерын тухай тэр хэлэв. -Хөвгүүдээс хамгийн ерөөлтэй нь Ашер.

Тэр ах дүүсийнхээ ивээлийг хүртэн, хөлөө тосонд булхаг. ²⁵Хаалганы чинь түгжээ хүрэл төмөр болж, амьдрах өдрийн чинь уртад хүч чадал оршино. ²⁶Иешуруны Бурхан шиг өөр хэн ч алга. Тэрээр чамд туслахаар тэнгэрийг хөлөглөн унаж,

огторгуйд сүр жавхлангаа бадраадаг. ²⁷Мөнхийн Бурхан бол орших газар. Түүний мөнхийн мутар доор чинь байна. Тэрээр чиний дайснуудыг өмнөөс чинь зайлуулж, ”Устга” хэмээн айлдсан. ²⁸Израиль амар түвшин сууж, Иаковын булаг нь үр тариа, шинэ дарсны газарт ганцаархнаа байна. Түүний тэнгэр бас шүүдэр буулгадаг. ²⁹Израиль аа! Чи ерөөлтэй ээ! ЭЗЭНий авралыг хүртсэн чам шиг ард түмэн хэн юм бэ? Тэр бол чамд туслах бамбай, чиний сүр жавхлант илд юм. Тиймээс дайснууд чинь чамд захирагдаж, чи тэдний мөргөлийн өндөрлөгүүдийг гишгэчнэ.(Дэд хууль 33:24-29 АБ 2004)

31.4 ЭЗЭН өөрийн зарц Иаковыг аварсан

²⁰Вавилоноос гарч, халдеичуудаас зугтаа! “ЭЗЭН Өөрийн боол Иаковыг аварлаа” гэж баярт дуугаар зарлаж, үүнийг тунхаглан, газрын хязгаар хүртэл дэлгэрүүлэгтүн. ²¹Тэр тэднийг цөлөөр дагуулах үед тэд цангаагүй. Тэр тэдний төлөө хаднаас ус гаргаж, хадыг хагалан ус оргилуулав. ²²“Хилэнцтэнд амар тайван байхгүй” гэж ЭЗЭН айлдав. (Исаиа 48:20-22 АБ 2004)

[] Бүх зүйлд Бурханы тогтоосон цаг хугацаа байдгийг та мэдэх үү ?

31.5 Бурханы нам гүм байдал ба Бурханаас эмээхүй

¹¹“Намайг зүрхэндээ хадгалж дурсалгүй, худал хэлж байхдаа чи хэнээс эмээж зовнисон бэ? Би удаан хугацааны турш чимээгүй байсан учраас чи Надаас эмээхгүй юу? ¹²Би чиний зөв шударгыг болоод үйлсийг чинь тунхаглана. Гэвч тэдгээр нь чамд ашиггүй. ¹³Орилж хашхирахад чинь чамайг шүтээний цуглуулга чинь авраг! Харин салхи тэднийг чинь бүгдийг нь хийсгэж, амьсгал ч тэднийг авна. Харин Надад хоргодогч нь газрыг өмчлөн, Миний ариун уулыг эзэмшинэ”. (Исаиа 57:11-13 АБ 2004)

[] Гэмшлийн үр дүнд шүүлт таны хувьд хойшлогддог ч гэнэт ирнэ гэдгийг та мэдэх үү?

[] Бурхан таны хоргодох газар мөн үү?

31.6 Мосе Израилийг ивээсэн нь "Хэрэв та бүрэн дуулгавартай байвал"

¹Хэрэв чи өөрийн Бурхан ЭЗЭНд дуулгавартай байж, миний өнөөдөр чамд тушааж буй Түүний бүх тушаалыг хичээнгүйлэн дагаж мөрдвөөс ЭЗЭН Бурхан чинь чамайг газар дэлхий дээрх бүх улс үндэстнээс илүү өндөрт тавина.

²Хэрэв чи өөрийн Бурхан ЭЗЭНд дуулгавартай байвал эдгээр бүх ерөөл чам дээр бууж, чамд хүрнэ. ³Чи хотод ч ерөөгдөнө, хөдөөд ч ерөөгдөнө. ⁴Биеэс чинь төрөх үр хүүхэд, газрын чинь ургац, мал амьтдын чинь төл, үхэр, хонины чинь төл ерөөгдөнө. ⁵Чиний сагс, талх исгэдэг сав ерөөгдөнө.

⁶Чи орохдоо ч ерөөгдөнө, гарахдаа ч ерөөгдөнө. ⁷Чиний эсрэг босох дайснуудыг ЭЗЭН чиний өмнө ялагдахад хүргэнэ. Тэд чам уруу нэг замаар довтолж, чамаас долоон замаар зугтана.

⁸ЭЗЭН чиний тариа будааны агуулах, чиний гар оролцох бүх зүйлд ерөөл айлдана. ЭЗЭН Бурханаас чинь чамд өгч буй тэр газарт Тэр чамайг ерөөнө. ⁹Хэрвээ чи ЭЗЭН Бурханыхаа тушаалыг сахиж, Түүний замаар явбаас ЭЗЭН чамд тангарагласан ёсоороо чамайг Өөрийн ариун ард түмэн болгон байгуулна.

¹⁰Тэгвэл чамайг ЭЗЭНий нэрээр дуудагдахыг газар дэлхий дээрх бүх ард түмэн хараад, чамаас айх болно. ¹¹ЭЗЭНий чамд өгөхөөр чиний өвөг дээдэст тангарагласан газар дээрээ чиний эд хөрөнгийг, биеэс чинь төрөх үр хүүхэд, малын чинь төл, газрын чинь ургацыг арвин болгоно.

¹²Газар дээр чинь цаг улиралд нь хур бороо оруулж, гарын чинь аливаа ажил үйлсийг ивээхийн тулд ЭЗЭН чиний төлөө огторгуйн сайхан сан хөмрөгөө нээнэ. Олон үндэстэн чамаас зээлнэ. Харин чи зээлэхгүй. ¹³Хэрэв миний өнөөдөр чамд тушааж буй ЭЗЭН Бурханыхаа тушаалыг чи сахин үйлдэхийн тулд тэдгээрийг сонсвол ЭЗЭН чамайг сүүл болгохгүй, толгой болгоно. Чи доор орохгүй ямагт дээр нь байна. ¹⁴Өнөөдөр миний та нарт тушааж буй аливаа үгнээс баруун тийш, зүүн тийш хазайн, өөр бурхдад үйлчлэхээр дагаж болохгүй. (Дэд хууль 28:1-14 АБ 2004)

⁹Би бол үүд мөн. Хэрэв хүн Надаар орвол, тэр аврагдах болно. Орж, гарч, тэжээлээ олно. (Иохан 10:9 АБ 2004)

[] Бүрэн дуулгавартай байхад хэдэн төрлийн ерөөл адислал ирдэг болохыг та мэдэх вэ?

[] Энэ нь яагаад та нар дээр ирэхээ больдогийг та мэдэх үү?

[] Таны сүнсийг эзэлж сүйрүүлэхийн тулд Бурханы үгийг эсэргүүцэн зогсуулахын тулд Сатан махан бие, оюун санааны хүслийг өгөхийн тулд бүх зүйлийг хийх болно гэдгийг та мэдэх үү ?

[] Түүний адислал таныг толгой болгож бусдад өгдөг болгодог болохоос биш сүүл болгож, гуйлга гуйдаг болгодог биш гэдгийг та мэдэх үү ?

31.7 Хүн ба Бурхан гэрээ байгуулсан

¹⁶ЭЗЭН Бурхан чинь өнөөдөр чамд энэ зарлиг хууль тогтоолыг дагаж мөрдүүлэхээр тушааж байна. Тиймээс чи тэдгээрийг бүх зүрх, бүх сэтгэлээрээ хичээнгүйлэн дагаж мөрд. ¹⁷Өнөөдөр чи ЭЗЭНийг өөрийн Бурхан гэж зарлан, Түүний замаар явж, Түүний зарлиг тушаал, хууль тогтоолыг сахиж, дуу хоолойг нь сонсохоо тунхаглалаа. ¹⁸ЭЗЭН ч бас чамд амласан ёсоороо өнөөдөр чамайг Өөрийнхөө эрхэм нандин ард түмэн хэмээн зарлан, Өөрийнхөө бүх тушаалыг сахиулна гэдгийг тунхагласан. ¹⁹Мөн чамайг Өөрийн бүтээсэн бүх улс үндэстний дээр магтаал, алдар, хүндлэлээр дээдлэн, айлдсан ёсоороо чамайг ЭЗЭН Бурханы ариун ард түмэн болгохоор тунхагласан гэв. (Дэд хууль 26:16-19 АБ 2004)

¹⁵Тэр тэдэнд -Та нар бол хүмүүсийн өмнө өөрсдийгөө зөвтгөгчид юм. Гэвч Бурхан та нарын зүрхийг мэднэ. Яагаад гэвэл хүмүүсийн эрхэмлэдэг зүйлс нь Бурханы өмнө жигшмээр юмс байдаг. ¹⁶Хууль ба Эш үзүүлэгчид Иоханыг иртэл тунхагласан юм. Тэр цагаас хойш Бурханы хаанчлалын сайн мэдээ дэлгэрч, хүн бүр тийшээ орохоор хүчлэн байна. ¹⁷Гэвч Хуулиас өчүүхэн зураас ч алга болохоос тэнгэр газар өнгөрөн одох нь илүү хялбар билээ. ¹⁸Эхнэрээ явуулчихаад өөр нэгэнтэй гэрлэгч аливаа хүн завхайрагч юм. Нөхрөөсөө салсан нэгэнтэй гэрлэгч нь завхайрсан болно. (Лук 16:15-17 АБ 2004)

¹¹Харин та нарын дундах хамгийн агуу нь зарц болог. ¹²Өөрийгөө өргөмжлөгч нь дорд болгогдох бөгөөд өөрийгөө дорд болгогч нь өргөмжлөгдөх болно. (Мат 23:11-12 АБ 2004)

[] Та Есүс Христийг дагахаар шийдсэн үү?

[] Бурханы хаанчлал уруу өөрийн замаа хэрхэн оруулахаа та мэддэг үү?

31.8 Ерөөлийг сонгох

¹¹Өнөөдөр миний чамд тушааж буй энэ тушаал бол чамд тийм ч хэцүү зүйл биш, алс холын ч зүйл биш, ¹²тэнгэрт байгаа зүйл ч биш учир чи “Биднээр тэр тушаалыг сахиулахын тулд түүнийг бидэнд авчирч, бидэнд сонсгохоор хэн бидний төлөө тэнгэрт гарах юм бэ?” гэж хэлэхээр юм биш. ¹³Энэ бол далайн цаана байгаа зүйл ч биш учир чи “Биднээр тэр тушаалыг сахиулахын тулд түүнийг бидэнд авчирч, бидэнд сонсгохоор хэн бидний төлөө далайг гатлах юм бэ?” гэж хэлэхээр юм биш. ¹⁴Харин үг нь чамд тун ойрхон, чиний аманд, чиний зүрхэнд байна. Энэ нь чи түүнийг сахихын тулд юм.

¹⁵Үзэгтүн! Би өнөөдөр чиний өмнө амь ба аз жаргал, үхэл ба гай зовлонг тавьялаа. ¹⁶Би өнөөдөр чамд ЭЗЭН Бурханаа хайрлаж, Түүний бүх замаар явж, Түүний тушаал, зарлиг, хууль тогтоолыг сахихыг тушааж байна. Тэгвэл чи амьдран, өнөр өтгөн болж, ЭЗЭН Бурхан чинь чиний эзэмшихээр очиж буй газарт чамайг ерөөнө.

⁷Харин чиний зүрх эргэж, дуулгаваргүй байж, уруу татагдан, өөр бурхдад мөргөж, тэдэнд зарагдвал ¹⁸та нар гарцаагүй сөнөнө гэдгийг би өнөөдөр та нарт тунхаглаж байна. Иорданыг гатлан эзэмшихээр очиж буй тэр газартаа та нар удаан амьдрахгүй. ¹⁹Би өнөөдөр тэнгэр газрыг дуудаж та нарт гэрч болгон, чиний өмнө амь ба үхэл, ерөөл ба хараалыг тавья. Чи болон чиний үр удам амьдрахын тулд амийг сонгож, ²⁰ЭЗЭН Бурханаа хайрлан, Түүний үгийг дуулгавартай дагаж, Түүнээс зуурч бай. Тэр бол

чиний амь амьдрал, чиний амьдрах хугацаа юм. Тиймээс чиний өвөг дээдэс Абрахам, Исаак, Иаков нарт өгөхөөр ЭЗЭНий тангарагласан тэр газарт чи амьдрах болно.
(Дэд хууль 30:11-20 АБ 2004)

Та юу сонгох байсан бэ?

Та хүүхдэдээ юу гэж зөвлөх вэ?

Та бусдад санал болгох зүйлээ өөрөө хийж байна уу?